

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР, “ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ САЛБАР ДУНДЫН УЯЛДААГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА, МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:


“19.5.Хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 344, 2024 оны 166 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд “Өвлийн идэш” арга хэмжээг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Шадар сайд, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны дарга С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгав:

1.“Хоршоологчдоос-Хотынхондоо” уриан доор хэрэгжүүлэх “Өвлийн идэш” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарт;

2.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд орон нутагт байгуулагдсан малчдын хоршоодыг “Өвлийн идэш” арга хэмжээнд оролцуулж, бүтээгдэхүүнийг нь худалдах, зах зээлд нийлүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэн, холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын алба (Ё.Азжаргал), “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” (Ц.Алтантуяа)-нд;

3.“Өвлийн идэш” арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР